68- 10-сар 6 ш


Орон бүхний пролетари нар нэгдэгтүн

# Дөрөв дугаар ТАВАН ЖИЛ

Төв аймгийн намын хороо,
А.Д.Х. Гүйцэтгэх захиргааны сонин.

21 дэх жилдээ
№ 80 (1769)

1968 ОНЫ
10 ДУГААР САРЫН 28

ДАВАА


## Мал өсгөх улсын төлөвлөгөө

1968 оны мал өсгөх улсын төлөвлөгөөний биелэлтийг дүгнэхэд 2 сар үлдэв.

Энэ жил тус орны ихэнх нутагт тохиолдсон ган зудын бэрхшээлийн улмаас мал аж ахуйд учирсан хохирлыг аль болох богино хугацаанд бүх нөөц бололцоогоо бүрэн ашиглах замаар нөхөж, малын цаашдын тогтвортой өсөлтийг хангахын чухлыг МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлөөс нам, улс, олон нийт,ХАА-н бүх байгууллага, нийт малчид хөдөлмөрчдийн хойшлуулшгүй зорилт болгон дэвшүүлсэн билээ.

Мал аж ахуйд учирсан хохирлыг нөхөж мал өсгөх улсын төлөвлөгөөг биелүүлэх тэмцэлд тус аймгийн хөдөлмөрчид их чармайлт гаргав.

Манай олонх нэгдэл-САА-нууд тэдгээрийн бригад фермүүд мал өсгөх нөөц бололцоогоо судлаж төлөвлөгөө боловсруулан ажиллаж юуны урьд малын зүй бусын хорогдлыг багасган мал аж ахуйн материаллаг баазыг бэхжүүлж өвлийн бэлтгэлийг хангах мал сүргийг зун намрын улиралд тарга хүч авахуулах зэрэг ажиллагаанд нилээд алхам хийв.

Үүний үр дүнд Баянбараат,Борнуур, Эрдэнэ, Сэргэлэн зэрэг нилээд сумд мал өсгөх улсын төлөвлөгөөг давуулан биелүүлэх бололцоотой болжээ.

Гэвч зарим сумд мал өсгөх төлөвлөгөөг биелүүлэхэд нарийн тооцоо судалгаагүй хандаж хүч бололцоогоо эртнээс дайчилж ажиллаагүйгээс олон тооны төл ба том малыг хорогдуулж мал өсгөх улсын төлөвлөгөөг биелүүлэх бололцоог алдахад хүрч байна.

Урьдчилсан судалгаа тооцооноос үзвэл Лүн, Эрдэнэсант, Өндөрширээт зэрэг сумдын мал өсгөх улсын төлөвлөгөөний биелэлт нь бат найдвартай биш байна.

Зарим сум—нэгдэл, САА-нууд малаа сар бүр тоолж судалгаа дүгнэлт хийхгүй урсгалаар явж ирснээс үзэхэд нам, улс, ХАА-н зарим байгууллагууд мал аж ахуйг ерөнхийлж удирддаг арга барилаас салж чадаагүйг харуулж байна. 1968 оны мал өсгөх улсын төлөвлөгөөг биелүүлэхэд одоо үлдэж байгаа хугацаанд мал сүргийн тооцоо судалгааг нарийн хийж ялангуяа малын зүй бусын хорогдлыг гаргуулахгүй байхад орон нутгийн нам, улс, ХАА-н байгууллагуудын гол анхаарал чиглэгдэх ёстой.

Түүнчлэн нэгдэл, САА-нууд өвлийн идэш хоолонд зориулан олон тооны малыг хавтгайруулан нядлах явдлаас болгоомжилж нарийн хяналт шалгалтын дор явуулах хэрэгтэй.

Өвчтэй туранхай малыг онд орохгүй гэж биеийн амрыг бодож нядлаад эцэст нь үлэмж махыг хэрэгцээгүй болгож үрэгдэл сүйтгэл болгодог дутагдлыг давтаж болохгүй. Харин тийм малыг бүх талын сайн нөхцөлд тэжээж онд оруулах ажлыг зохион байгуулах хэрэгтэй. Тус аймгийн хувьд өнгөрсөн жил мал олноор хорогдож байсан явдал нь байгаа бололцоогоо бүрэн ашиглаагүй, ялангуяа өвлийн бэлтгэлийг олигтой хийгээгүйгээс голлон шалтгаалсан билээ. Гэтэл зарим нэгдэл, САА тэдгээрийн дэргэдэх намын байгууллагууд мал хорогдсон шалтгаанд зохих дүгнэлт хийж зохион байгуулалтын удирдлагын аргыг сайжруулаагүйгээс малыг дулаан хашаа байр, ус хужир, өвс тэжээлээр хангах талаар энэ жил бас л олигтой өөрчлөлт гаргаагүй байна. Ингэхлээр мал аж ахуйн өвлийн бэлтгэлийн дутууг яаравчлан хангаж өвөл хаврын хатуу цагт мал хорогдохгүй байх бололцоо нөхцлийг хангах хэрэгтэй. Юуны урьд өсвөр насны мал өвчтэй ба тэжээгдэх малын сууриудад онцгой анхаарал тавьж түүнийг дулаан хашаа,байр ус, өвс тэжээл, хужир, нарийн арчилгаа маллагаагаар хангах хэрэгтэй.

Малын тарга хүчийг тогтоон онд сайн оруулахад мал сүргийг цастай ч байсан харз юмуу худгийн усаар усалж эрдэс тэжээлээр хангаж байх нь өнгөрсөн цаг зудтай тэмцсэн практик ажлаас шалгарсан туршлага тул үүнийг хаана ч хэрэгжүүлбэл зохино. Мал аж ахуйг эрхлэх асуудлыг үйлдвэрлэлийн нэгж бүрээс эхлэн сайжруулах ёстой.

Тэнд хүн бүрийг тодорхой ажилтай, ажил бүрийг тодорхой эзэнтэй болгож малчин, саальчин төлчин, мал аж ахуйн мэргэжилтэн хэн боловч ажилдаа бүрэн дүүрэн эзэн болж материалын болоод ёс суртахууны талаар бүрэн хариуцаж байхуйцаар ажлыг зохион байгуулбал зохино.

Мал сүргийг тарган тавтай өвөл жүүлэх тэмцэлд нийтийн хүчийг зохион байгуулж САА, нэгдэл, мал аж ахуйн бригад, ферм,суурь бүр мал өсгөх төлөвлөгөөг давуулан биелүүлэхийн төлөө тэмцэн ажиллах хэрэгтэй.

### ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ БИЕЛҮҮЛЭВ

Архустын САА-н Ядамхүү ахлагчтай талхны салбарын хамт олон Октябрийн социалист их хувьсгалын 51 жилийн ойг угтаж 10 дугаар сарын 25-нд жилийнхээ талх үйлдвэрлэх төлөвлөгөөг 101 хувиар биелүүлж сайхан амжилт гаргав.

**Ж.Сүрэнжав**

## ЗӨВЛӨЛТИЙН ХҮН САНСАРТ ДАХИН ГАРЛАА

ЗХУ «Союз—3» гэдэг сансрын хөлгийг дэлхийн хиймэл дагуулын тойрог замд хөөргөсөнтэй холбогдуулан тус аймгийн төвийн артелийн ажилчдын өргөн цуглаан боллоо. Цуглааныг артелийн дарга Нацаг нээж, аймгийн Намын Хорооны ажилтан Д.Дуламжав «Союз—3» хөлгийн нислэгийн тухай тодорхойярив. Дараа нь хивсэн тасгийн ажилчин Лхам үг хэлэв. Тэрээр «Союз—3» хөлгийн нислэг нь ЗХУ-ын шинжлэх ухаан техникийн бас нэг шинэ амжилт юм гэлээ.

**Манай сурвалжлагч**

■ Октябрийн социалист их хувьсгалын 51 жилийн ойн босгон дээр манай ах дүүгийн найрамдалт ЗХУ «Союз—3» гэдэг сансрын хөлгийг дэлхийн хиймэл дагуулын тойрог замд хөөргөсөн баярт мэдээг жирийн ажилчин би сонсоод маш их баярт сэтгэгдэл төрж, «Союз—3» сансрын хөлгийг жолоодож яваа ЗСБНХУ-ын иргэн,сансрын нисэгч, ЗХУ-ын баатар, ЗСБНХУ-ын гавъяат туршигч Г.Т.Береговойг сансрын энэ гайхамшигт нислэгээ амжилттай биелүүлж эх дэлхийдээ эсэн мэнд бууж ирнэ гэдэгт итгэл төгс байна.

**Бүрэн сумын холбоочин Ц.Бямбаа**

## Адуучдын хариуцлагыг өндөржүүлье

Аймгийн Намын Хороо, АДХГ Захиргаа,адууны аж ахуйн үйлдвэрлэлийн ажиллагаанд дүгнэлт хийж цаашид шаардагдах арга хэмжээнүүдийг авах, адуун сүргийн өсөлт хөгжилтийг сайжруулах, өвөлжилтийн ба төлийн бэлтгэлийг сайн хангуулах, нэгжээс ашиглах ашиг шимийн хэмжээг нэмэгдүүлэхэд адуучин, мал аж ахуйн мэргэжилтний хүчийг бүрэн чиглүүлэх зорилгоор 10 дугаар сарын 25-нд адуучдын зөвлөлгөөнийг хийлгэв. Адуун сүрэг бол ХАА-н нэгдэл, САА—нуудад тээврийн хэрэгцээнд ашиглагдаж их үүргийг гүйцэтгэдэг бөгөөд бусад төрлийн малаас дутуугүй олон төрлийн ашиг шим өгдөг билээ.

Тус аймгийн бүх малын 13,5 хувь нь адуун сүрэг байгаа бөгөөд жилдээ дундаж нийслэл Улаанбаатар хотын хөдөлмөрчдийн хэрэгцээнд 234 мянган литр айраг бэлтгэн нийлүүлж 15,2—16,6 мянган кг хөөвөр хялгас улсад тушааж байна.

Аймгийн ХАА—н нэгдлүүдийн МАА-гаас жилд орох орлогын 15,4 хувийг адууны аж ахуйгаас орох орлого эзлэж байна.

Адуун сүргийн ашиг шимийг нэмэгдүүлэхэд сүргийн тоо толгойг өсгөн үржүүлж хариулга маллагааг сайжруулан билчээрийг хувиартай ашиглаж, отроор тарга хүч сайн авахуулж адуун сүргийн нөхөн үйлдвэрлэлийг түргэтгэх явдал мөн болохыг тэргүүний сайчууд, аврага малчдын он удаан жилийн ажиглалт,амьдралын туршлага нотолж байна.

Тус аймгийн адууны аж ахуйн үйлдвэрлэлийг эрхлэн ажиллаж байгаа адуучин, саальчин, малчин, хөдөлмөрчдийн дотроос ажил бүтээлээрээ шалгарсан тэргүүний сайчууд олон арваараа төрдөг болжээ. Аль ч улиралд адуун сүргийн хариулга маллагааг тохируулж чаддаг ажилч байдлаараа аймагтаа алдаршиж сүүлийн 30 гаруй жил адуу маллахдаа ихээхэн туршлага хуримтлуулж хариуцсан адуун сүргээсээ ашиг шимийг сайн ашиглаж, төлий нь сайн бойжуулж байгаа аймгийн хошой аврага Борнуур сум—САА-н ахмад адуучин Чойжамц, сүүлийн 3 жил дараалан хариуцсан адууныхаа хөөвөр хялгасыг 100-103 хувь, унага бойжуулах төлөвлөгөөг 100 хувиар биелүүлсэн Мөнгөнморьт сум—нэгдлийн адуучин Зэвэгийн Сүндэв, сүүлийн 3 жилд 300 гаруй эмнэг сургасан Заамар сум—нэгдлийн адуучин Лэгжидийн Цэнд—аюуш,сүүлийн 2 жилд 18—25 гүү хариуцан сааж гүү нэг бүрээсээ 628—1013 литр сүү саасан Борнуур сум—САА-н залуу саальчин Нина, гүүний саалийн аймгийн 3 удаагийн аврага Борнуур сум-САА-н мянгат саальчин Гонгорын Дуламсүрэн нарын зэрэг амжилт бүтээл гаргаж байгаа ахмад адуучид, саальчид олон байна.

Тус аймгийн нэгдэл—САА-нууд урьд жилүүдэд олсон ололт амжилтаа бататгаж хуримтлуулсан туршлагатаа түшиглэж адууны аж ахуйн үйлдвэрлэлийг өөрчлөн сайжруулж чадаагүйгээс адууны аж ахуйн үйлдвэрлэлийн хувьд дутагдалтай явж ирсэнийг адуучдын анхдугаар зөвлөлгөөнд оролцогчид тодорхой баримтаар илрүүлэн заав.

Өнгөрсөн хаврын 3 өдрийн хүйтэн бороо цасан шуурганаар Өнжүүл, Бүрэн, Дэлгэрхаан, Эрдэнэсант, Өндөрширээт зэрэг нилээд сумд асар олон тооны адуу хорогдуулж үлэмж хохирол үзсэний дотор Бүрэн сумын «Бүрэндэлгэрэх» нэгдлийн 1 дүгээр бригадын адуучин Найдандорж,мөн бригадын Нацаг, 2 дугаар бригадын Батмөнх, Өнжүүл сумын «Ялалт» нэгдлийн 1 дүгээр бригадын адуучин Пүрэв, мөн сумын 3 дугаар бригадын адуучин Намжил нарын олон сууриуд 504—818 адуу хорогдуулсан байна.

Манай зарим адуучид нийгмийн асар их хөрөнгийг хариуцаж байгаа атлаа түүнд хайхрамжгүй хандан хариуцлага алдаж, олноор үхүүлэх, үрэгдүүлэх зэрэг зохисгүй байдал гаргаж алдсан адуугаа эрж олох, учруулсан хохирлоо төлж дуусгах талаар санаа сэтгэл зовохгүй сууж байна.

Адууны өсөлтийг аймгийн хэмжээгээр сүүлийн 7 жилээр аваад үзэхэд жил дараалан буурч 21,6 хувиар хорогдсоны 84,3 хувь нь зөвхөн сүүлийн 3 жилд хорогджээ. Үүний дотор Баянцогтын САА 1961 онд байсан адуугаа сүүлийн 7 жилд 17,5—50,4 хувь, Лүн 3,4—16,7 хувиар,Борнуур 25,5—85,7 хувиар тус тус хорогдуулсан ба Баянцогтын САА 100 хээлтэгчээс унага 35, Баянзүрх 40, Сэргэлэн 41-ийг бойжуулж авсан нь аймгийн дунджаас даруй 7-12 унагаар дутуу бойжуулж өөртөө байгаа адуу өсгөх асар их бололцоог алджээ.

Аймгийн хэмжээгээр адууны өсөлт туйлын хангалтгүй сүргийн дотор эзлэх хээлтэгчийн хувийн жин дөнгөж 26,9 хувьтай байгаа ба жил ирэх дутам

Төгсгөл нь 4 дүгээр нүүрт

төгсгөл (түрүүч нь 1 дүгээр нүүрт)

## Адуучдын хариуцлагыг өндөржүүлье

буурч байгаа явдал бол түүнд тавих хяналт шалгалт суларч адууны арчилгаа маллагаа эрс муудсантай холбоотой юм.

Сүүлийн 4 жилийн дотор аймгийн дүнгээр 13,7 мянган гүү хээл хаяж 47,0 мянган гүү сувайрч 41,0 мянган адуу зүй бусаар хорогдсон байна.

Аймгийн хэмжээгээр адууны 130 сууръ байгаагаас энэ онд унага бойжуулах төлөвлөгөөгөө биелүүлсэн сууръ бүх сууриин 29 хувь, хялгасны төлөвлөгөөг биелүүлсэн сууръ бүх сууриин 84,6 хувь, хөөврөө биелүүлсэн сууръ бүх сууриин 75,8 хувь, адууны дутагдалгүй сууръ бүх сууриин 34,7 хувь, зүй бус шалтгаанаар адуу хорогдуулаагүй сууръ бүх сууриин 2,3 хувийг эзлэж байгаа нь адууны маллагаа арчилгаа тордлого хир зэрэг байгааг нотлон харуулж байна.

Тус аймгийн адуу сүүлийн жилүүдэд хорогдож өсөхгүй байгаа шалтгаан бол манай зарим адуучдын ажил хариуцах хариуцлага сул, адууны хариулга маллагаа сууръ бүрд жигд сайжирч чадаагүй, түүнд тавих хяналт шалгалт хангалтгүй байгаагаас болж байна.

Энэ нь жилийн аль ч улиралд адуу манадаггүй, цас бороонд урууддуулж алдах, чононд идүүлэх, өвчин туссан ч эмчилдэггүй, авсан хүч таргыг нь тогтоох талаар анхаарал төдий л тавьдаггүйгээс гадна манай зарим адуучид адууг намар эрт усгүй газар хорьж усаар хатаах, эсвэл холоос усанд гүйлгэж тураах, хүйтэн цасан шуурга болоход уул толгодын бэл нөмөр нөөлөг газраар тогтоож тогтмол хөдөлгөж биеийн дулаацуулахгүй байдагаас болж адуу хүйтэнд шээж чадахгүй байсаар шээсэндээ хордож үхэх явдал гардаг байна.

Манай адуучид ийм байдлыг гаргахгүй байхын хамт тэргүүний адуучдын шилдэг туршлагуудыг ажилдаа өргөн хэрэглэж дадал заншил болгох хэрэгтэй.

Манай малын зарим эмч нар үхсэн малд акт бичихдээ нүдээр үзэхгүй, хүний ам, таамгаар бичих, үхсэн мал нэг бүрд тус тусад нь акт бичих ёстой байтал арав хорин малд бөөн бичих, чухам ямар өвчнөөр үхсэн болох нь тодорхойгүй, ийм баримт бичиг үйлдэж суудаг байна. Өндөрширээт сумын малын бага эмч Төмөрбаатар өөрөө үзээгүй атлаа хүний амаар 20—30 малд бөөнөөр нь акт өгч байсан ба бичсэн актанд нь малын зүс, нас, хүйс тодорхойгүй, өвчний онош байхгүйгээр акт тогтоож байсан байна.

Ийм байдалд дүгнэлт хийж нийгмийн хөрөнгийг үрэгдүүлэгчидтэй хатуу тэмцэл хийх хэрэгтэй байна.

Манай олонхи нэгдэл, САА-нуудад бага залуу насны морьдыг уналга эдэлгээнд сургах ажил хоцрогдонгүй, морьдыг тэргэнд хөллөж аж ахуйн дотоодын тээвэрт ашиглахгүй байгаагаас зарим сумдад унааны номхон морь ховордож байгаа ба өвс хадахад, морьдыг Өндөрширээт, Лүн, Дэлгэрхаан, Өнжүүл, Бүрэн, Баянцагаан, Баянбараат сумд хэрэглэхгүй байна.

Одоо тус аймагт жилдээ саалинд орвол зохих бүх гүүнийхээ дөнгөж 25 хувийг сааж айраг бэлтгэж байгаагаас үзэхэд аймгийн ХАА-н нэгдэл, САА-нууд адуунаас орох орлогын асар их нөөц боломжоог ашиглаж чадахгүй алдаж байгаа баримт мөн.

Хөдөлмөр хөнгөвчлөж гүүний саалийг механикжуулах талаар Сэргэлэн, Баянзүрх сумдын нэгдлүүд дээр гүүг цахилгаанаар саах тухай туршлага, үзүүлэх сургууль зохион явуулсан боловч одоо болтол манай зарим сумдад бүрэн биелэлээ олоогүй, туршлага явуулсан Баянзүрх, Сэргэлэн сумдад ч олигтой ажил болохгүй байгаа ба 1967-68 онуудад 5 сум нэгдэл гүүний цахилгаан саалтуур авсан нь одоо болтол ажиллуулж ашиглахгүй үр ашиггүй хадгалж байна. Энэ талаар аймгийн адуучдын анхдугаар зөвлөлгөөн дээр үг хэлсэн БНМАУ—ын хөдөлмөрийн баатар Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын адуучин Ичинхорлоо, БНМАУ—ын аврага төлчин Баян сумын тэмээчин Балдан, аймгийн 2 удаагийн унага бойжуулалтын аврага Борнуурын САА-н адуучин Чойжамц, аймгийн прокурор Лхамсүрэн, шүүхийн орлогч дарга Бадарч нарын олон хүн үг хэлж, ажлын хаа арга туршлагаасаа тодорхой ярьж зөвлөлдөв.

Зөвлөлгөөнд оролцогчид мал аж ахуйн үйлдвэрлэлийг хөтлөн удирдах арга ажиллагааг эрс сайжруулж, адуун сүргийн өсөлтийг нэмэгдүүлэхийн тулд ойрын хугацаанд хорогдлыг нөхөж нэгжээс ашиглах ашиг шимийн хэмжээг нэмэгдүүлэх 1968—69 оны мал өвөлжилт, төл хүлээн авах бэлтгэл ажлыг урьд урьдаас улам илүү сайн зохион байгуулж малчид хөдөлмөрчдийнхөө урьд жилүүдэд олж байсан сайхан туршлага ололтод тулгуурлан 4 дүгээр таван жилийн төлөвлөгөөний үлдэж байгаа 2 жилд дутагдлаа нөхөхийн тулд байгаа боломжоо нөөцөө шавхан дайчилж одоо байгаа адуугаа аймгийн дүнгээр 4,2 хувиар, ХАА-н нэгдэл, САА-н нийгмийн адууг 7,1 хувиар өсгөх зорилт тавив.

Энэ зорилтоо биелүүлэхийн тулд ахмад адуучдын арга туршлагаас цуцалтгүй суралцах мал аж ахуйн хүнд хүчир ажлыг хөнгөвчилж гүүг цахилгаанаар саах аргыг ХАА-н нэгдэл, САА бүрд нэвтрүүлэх, билчээрийг улирлын байдлаар зохицуулан, хариулга маллагааг тогтмолжуулан сайжруулах, адууны отрыг намар эртнээс зохион байгуулж отрын төлөвлөгөө боловсруулан, хүн хүчийг хувиарлан зохицуулж адуу нэг бүрт эрүүл мэндийн ба тарга хүчний үзлэг явуулахын хамт адууны хариулга маллагаа маналтыг сайжруулан нэгжээс ашиглах ашиг шимийг дээд хэмжээнд хүргэх, адуун сүргийн нөхөн үйлдвэрлэл болох хээлтүүлэг үржлийн ажлыг эн тэргүүнд анхаарч ажиллаж байх нь хамгийн чухал гэж үзэв.

Адууны хариулга маллагааг тогтмолжуулан байнгын манаатай болгох, сууръ бүрийн ажлыг жигдрүүлэн ажиллаж адууны гарз хохирлыг эрс багасгаж, түүнд тавих хяналт шалгалтыг сайжруулж, зудын хор уршгийг нөхөн адуу өсгөх улсын төлөвлөгөөг биелүүлэхийн төлөө бүхий л хүчээ дайчлан ажиллаж, адуучдын анхдугаар зөвлөлгөөний шийдвэрийг амьдралд хэрэгжүүлэн биелүүлэх явдал орон нутгийн нам, захиргаа, хөдөө аж ахуйн байгууллагууд болон нийт адуучдын өмнө хойшлуулшгүй зорилт болон зогсож байна.

Зөвлөлгөөнд аймгийн АДХ—ын Гүйцэтгэх • Захиргааны дарга Ц. Жамсран оролцож, адуучдад үнэтэй санал зөвлөлгөө өгч дэлгэрэнгүй үг хэлэв.

Тус зөвлөлгөөнөөс аймгийн нийт адуучдад хандаж уриалга гаргав.

Мөн хөдөө аж ахуйн нэгдэл, сангийн аж ахуйн адууны хариулга маллагааг сайжруулж ашиг шимийг бүрэн ашиглаж зүй бусын хорогдлыг багасгаж үр бүтээл, идэвхи зүтгэлтэй ажилласан олон адуучдыг шагнаж урамшуулав.

**Н. Мөнхөө**

## Эднийхэн ажил сайтай явна

Батсүмбэрийн САА-н гуанзны хоол амттайхан шүү гэж аян замынхны ярианаас бишгүйдээ сонссон юм.

Бас ахлах тогооч Ханд гуай Булган хоёрыг эсэлдэг үйлчилдэг сайн тогооч нар гэж магтахыг бас олонтоо дуулсан билээ. Гуанзны ажилтан Хандсүрэнтэй уулзаж, үйлчилгээнийхээ ажлын талаар танилцуулна уу гэхэд сайхан зантай тэр эмэгтэй уриалгахан хүлээн авч ийнхүү ярив.

—Манай гуанзны хамт олон нийтийн хоолны тэргүүний ажилчдын улсын анхдугаар зөвлөлгөөний шийдвэрийг мөрдлөг болгон 1968 оны 1, 2, 3 дугаар улирлын төлөвлөгөөг 100—137,6 хувиар биелүүллээ.

Энэ онд 72175 хүнд үйлчлээд байна.

3 дугаар улиралд 2 ээлжийн буфет ажиллуулж талх, боов, чихэр, тамхи, шүдэнз зэрэг өргөн хэрэгцээний бараа борлуулан 90 мянга гаруй төгрөгийн гүйлгээ хийж орлогын төлөвлөгөөг 138 хувиар биелүүлсэн.

Манай гуанзанд туршлагатай залуу тогооч Булган хуушуууртай шөл, холимог хуурга, ногоотой мантуу зэрэг 3—4 нэр төрлийн шинэ хоол санаачлан хийв.

Мөн ахмад тогооч Ханд гуай этүүртэй хуурга, сүүтэй бууз зэрэг шинэ хоолоор олон түмэндээ үйлчиллээ.

Бас бид өөрсдийн хүчээр 50 кг жимс түүж компот хийлээ.

Ажилдаа санал гомдлын дэвтэрт бичигдсэн зүйлс, олон түмний хүсэлт шаардлагыг байнга тусган авдаг.

Бид намрын тариа хураалтын үеэр төвийн гуанзны ажиллах цагийг уртасгаж, хээрийн гуанз 2-ыг ажиллууллаа.

Хээрийн гуанзны тогоочоор ажилласан ахмад ажилчин Дулмаажав гуай, Отгон нар сайн ажилласан. Нөгөөтэйгүүр манай гуанзныхан техникийн тос 50 кг, яс 1735 кг-ийг ХБ-ийн ангидаа тушаасны гадна үхрийн шийр 800-г хуйхлаж худалдсан зэргээс 1878 төгрөгийн цэвэр ашиг оллоо.

Өвлийн бэлтгэлээ бид 6 сараас эхлэж пийшин барилга засварыг 7 дугаар сард дуусгаж, 320 кубм мод татан авч бүгдийг хөрөөдүүлсэн.

Хоолны өвлийн нөөцөнд төмс 10 тонн, лууван [illegible] тонн, манжин 4 тонн, байцаа 8 тонныг татан авч зоорилоод байна гэв.

**Л. Батсүх**

## Үндэсний бөхийн чуулга уулзалт

Дорноговь аймгийн Сайншанд хотод үндэсний бөхийн чуулга уулзалт саяхан явагдаж өнгөрлөө. Энэ чуулга уулзалтад Дорноговь нийгэмлэгийн хоёр баг, Алдар, Төв аймгийн багууд оролцлоо.

Энэ уулзалтад Алдар нийгэмлэгийн баг 1 дүгээр байр, Дорноговийн 2 дугаар баг 1 байр, манай баг 3 дугаар байр, Дорноговийн 1 дүгээр баг 4 дүгээр байр тус тус эзлэв.

Нэг бүрчилсэн дүнгээр Одсүрэн, Өвгөнхүү, Долгорсүрэн, Одсүрэн нар 1, 4 дүгээр байр, манай бөх Баатар 5 дугаар байр эзэллээ.

Энэ чуулга уулзалтаар бөхчүүд харилцан арга мэх туршлагаа солилцож, ялангуяа улсын начингуудаас маш их зүйлийг сурч авлаа.

Иймээс дээрхи уулзалтаар олсон амжилтаа улам бататгаж энэ оны 11 дүгээр сард өөрийн аймагт явагдах зүүн аймгуудын үндэсний бөхийн ба волейболийн тэмцээнд одоо ноос эхлэн сайн бэлтгэж оролцох явдал чухал байна.

**Ц. Гомбо**

## *Сүүлчийн шуудангаар*

Саяхан Мөнгөнморьт сумын төвийн хөдөлмөрчдөд аймгийн Соёлын ордны урлагийн бригадынхан концерт болон «Зорголын гүнж» гэдэг жүжиг тогложж сонирхууллаа.

Үзэгчид жүжигчин Дулмаа, Нямсүрэн, Сэрээтэр нарын тоглолтыг бусдаасаа илүү амжилттай боллоо гэж үнэлэв.

**Б. Должин**

*Хариуцлагатай эрхлэгчийг* Б. ЦЭРЭНДАШ

## ЗАРЛАЛ

Баянзүрх сумын харъяат Пэрэнлэй овогтой Намжил нь олон хүүхэдтэй эхийн тэтгэвэр авах 01133 тоот дэвтрээ гээгдүүлсэн тул хүчингүй болгов.

(Х—000155) «Анхдугаар таван жил» сонины үйлдвэрт хэвлэв